

Дархан-Уул аймгийн Соёл, Урлаг, Аялал жуулчлал,
Залуучуудын газрын 2024 оны 11 дугаар сарын 27 өдөр
01/385 тоот албан бичгийн хавсралт



ДАРХАН-УУЛ АЙМАГ

“МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 27

Дархан-Уул аймаг

Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 22 дахь жилдээ 16 нас хүрсэн залуус "ИРГЭНИЙ АНДГАЙ" өргөж, Монгол Улсын Иргэний үнэмлэхээ ёслол төгөлдөр авах үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Дархан-Уул аймгийн Залуучууд театрын их танхимд зохион байгууллаа.

Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Боловсролын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв хамтран зохион байгуулж 16 нас хүрсэн 535 хүүхдэд батламж гардуулж, иргэний андгай өргүүлсэн. Тэдний төлөөлөл болсон 30 хүүхэд аймаг орон нутгийн удирдлагуудаас иргэний үнэмлэх, батламжаа гардан авлаа.

Иргэний үнэмлэхээ гардан авч буй хүүхдүүдэд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Хүрэлчулуун баяр хүргэн, түүхт өдрийн мэндийг дэвшүүлж 16 настнуудыг төлөөлөн Оюуны ирээдүй сургуулийн 11-1 ангийн сурагч Ж.Төрболд, 11-11 ангийн сурагч Э.Эрхсаран нар нар сэтгэгдэл хэллээ. Тэд "Улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах эрдэм мэдлэгтэй иргэн болцгооё" хэмээн үеийнхэндээ уриалж, Монгол Улсын иргэн гэж дуудуулах эрх чөлөө, тусгаар тогтнолыг олгосон өвөг дээдэстээ талархаж байгаагаа илэрхийлэв. Мөн Оюуны Ирээдүй сургуулийн 12-р ангийн сурагч Б.Нандинхүслэн "Тусгаар тогтнолын үнэ цэнэ" илтгэл тавив.

Тус үйл ажиллагааг аймгийн хэвлэл мэдээлэл, орон нутгийн DBS, RGB телевиз, ЦЭЦ.мн цахим сайт, аймгийн Мэдээлэл технологийн албаны Дархан-Уул аймаг цахим хуудас болон хамтран зохион байгуулагч байгууллагуудын цахим хуудсаар тус тус сурталчлан ажиллалаа.

Тус үйл ажиллагаанд 2 уран бүтээлч, 8 хүүхэд оролцож урлагийн үзүүлбэр үзүүлсэн. Иргэний андгай өргөх ёслолыг зохион байгуулахад нийт 1,586,000 төгрөгийг зарцуулж, холбогдох зардлыг аймгийн Соёл, урлаг аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 22 -ны өдрийн А/30 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.

Линк болон зурган мэдээллийг хавсаргав:

<https://www.facebook.com/share/v/UJu1fSZCns6vsowT/?mibextid=WC7FNe>

(1) Facebook

<https://fb.watch/w6ggovQy3s/>

<https://fb.watch/w6gw22KAe9/>

(1) Facebook



Зураг 1, 2. Тус үйл ажиллагаанд ЕБС, коллежийн 16 настай 530 хүүхэд хамрагдав.



Зураг 3, 4. Аймаг, орон нутгийн удирдлагууд оролцлоо.



Зураг 5, 6. 16 настнуудыг төлөөлж Ж.Төрболд, Г.Үжин нар “Иргэний андгай”-г индэрт уншиж байгаа нь



Зураг 7, 8, 9, 10. Иргэний андгай өргөх ёслол

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Х.Алтан-Асаг* Х.АЛТАН-АСАГ

.....ooOoo.....